



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг
аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй холбосон
цахим хуудас ажиллуулах тухай

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.1 дэхь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:


Нэг. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй холбосон цахим хуудсыг үйл ажиллагаанд оруулах, бэлтгэл ажлыг ханган ажиллахыг программист /П.Энхтуяа/, сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзаяа/ нарт даалгасугай.

Хоёр. NATIONAL MENTAL HEALTH CENTER OF MONGOLIA цахим хуудсаар дамжуулан мэдээллээр хангах, тогтвортой байнгын үйл ажиллагаатай байлгахыг эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн эмч /Т.Мандхай/, сургалт хариуцсан мэргэжилтэн эмч /Б.Батцэцэг/, программист /П.Энхтуяа/, сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзаяа/, статистикч /О.Соёл-Эрдэнэ/ нарт даалгасугай.

Гурав. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй холбосон цахим хуудас бий болсонтой холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, мэдээллийн технологийн алба эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

00110

СЭМҮТ-ийг ерөнхий захирлын
2015 оны 02 сарын 05 нийгмийн
23 дугаар тушаалын I хэсвэрт



Хийгдэх ажлын төлөвлөгөө

| № | Хийгдэх ажлууд | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|---------------------------------------------------------------------|
| 1 | Олон нийтийн сүлжээний http://www.facebook.com -д NATIONAL MENTAL HEALTH CENTER OF MONGOLIA гэсэн групп нээх | 2011.08.04 | Т.Мандхай |
| 2 | СЭМҮТ-ийн NATIONAL MENTAL HEALTH CENTER OF MONGOLIA цахим хуудсанд аймаг, дүүргийн сэтгэцийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг бүртгэн нэмэх | 2015.02.13- 2015.02.27 | Л.Бямбадорж |
| 3 | СЭМҮТ-ийн NATIONAL MENTAL HEALTH CENTER OF MONGOLIA цахим хуудсанд группын гишүүд бүр мэдээлэл оруулах, танилцах | Тухайн тохиолдол бүрт | Т.Мандхай Б.Батцэцэг Г.Мөнхзаяа П.Энхтуяа О.Соёл-Эрдэнэ |